




# МҮХАҮТ

## МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ



2022.03.02

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

Дугаар / 22.02

## ЕВРОПЫН ХОЛБООНЫ ТӨЛӨӨЛӨГЧИДТЭЙ УУЛЗЛАА



МҮХАҮТ, Европын холбооны төлөөлөгчидтэй хийх уулзалтыг 2 дугаар сарын 28-нд зохион байгууллаа. Уулзалтад Европын Холбооны Зүүн ази болон Номхон далайн бүсийг хариуцсан захирал Жан Луи Виль, Европын Холбооноос Монгол Улсад суугаа Элчин Сайд ноён Аксель Никэйз болон бусад төлөөлөгчидтэй МҮХАҮТ-ын Дарга Т.Дүүрэн, Ерөнхий нарийн бичгийн дарга С.Баясгалан, EuroChamber, кластеруудын төлөөллүүд оролцов.

Энэ үеэр МҮХАҮТ-аас Худалдааг дэмжих чиглэлээр Европын холбоотой хамтран ажилласан талаар мэдээлэл хийж, EuroChamber, Монголын Экспортын Кластер Сүлжээ ТББ-ыг танилцууллаа. Мөн нэмүү өртөг шингээсэн бараа бүтээгдэхүүнийг төрөлжүүлэхэд, Европын зах зээл рүү экспортыг нэмэгдүүлэхэд талууд хамтран ажиллахаар ярилцсан юм.



## “ГРИЙН ГРУПП” ХХК МҮХАҮТ-ЫН “ПЛАТИНУМ” ГИШҮҮНЭЭР ЭЛСЛЭЭ

Үндэсний брэнд бүтээгч Грийн групп нь 2007 онд үүсгэн байгуулагдсан, 750 гаруй ажилтантай, хөдөө аж ахуйн уламжлалт бизнест инновац шингээн, шинэ шийдлээр түүчээлж буй хамт олон юм. Платинум гишүүний гэрчилгээг гардуулах үеэр МҮХАҮТ-ын дарга Т.Дүүрэн МҮХАҮТ-аас уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажлуудаа танилцуулж, цаашид хамтран ажиллах чиглэлийн талаар санал солилцлоо.


МҮХАҮТ-ын ПЛАТИНУМ гишүүн болсноор [www.trademongolia.mn](http://www.trademongolia.mn) цахим хуудсанд байгууллагынхаа танилцуулга, үйлчилгээ, мэдээ мэдээллээ байршуулах, оны онцлох аж ахуйн нэгжийн аянд оролцох, гадаад худалдааны зөвлөгөө мэдээлэл авах, гадаад улсад зохиогдох бизнес форумд хамрагдах, дотоод, гадаадын үзэсгэлэн худалдаанд бараа бүтээгдэхүүнээрээ оролцох зэрэг олон давуу талуудтай билээ.



ХӨТӨЛБОРТ ОРОЛЦОГЧИД  
МҮХАҮТ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ  
ТАНИЛЦАВ



ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН  
ЦОГЦ СУРГАЛТЫГ ТОГТМОЛ ЗОХИОН  
БАЙГУУЛЖ БАЙНА



БУС НУТГИЙН ХӨГЖИЛД ЗАЛУУСЫН  
ОРОЛЦОOG НЭМЭГДҮҮЛЭХЭД  
ХАМТАРЧ АЖИЛЛАНА



ХААН БАНК ШИНЭ АЛСЫН ХАРАА,  
ЭРХЭМ ЗОРИЛГОО ТАНИЛЦУУЛЛАА

## МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

### ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОГЧИД МҮХАҮТ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАВ



Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг хөгжүүлэх, чадавхжуулах Инкубаторийн сургалт, хөтөлбөрийг Азийн сангаас МҮХАҮТ, Голомт банк, Ганабел институттэй хамтран хэрэгжүүлж байна.

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд бизнесээс эхлүүлэх, өргөжүүлэхэд шаардлагатай бүхий л төрлийн сургалт, ганцаарчилсан ментор хөтөлбөрүүд болон харилцаа холбоогоо өргөжүүлэх арга хэмжээнүүдэд хамруулан чадавхжуулах тус хөтөлбөрийн 6 дахь удаагийн оролцогчдод МҮХАҮТ-ын үйл ажиллагаа, үйлчилгээг танилцуулах уулзалтыг зохион байгууллаа.

Уулзалтын үеэр Танхимиын үйл ажиллагаа, үйлчилгээ, гишүүнчлэл, сургалт, арбитрын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, хөтөлбөрийн оролцогчид өөрсдийн бизнесийн хүрээнд хамтран ажиллах боломжуудтай танилцав.



### ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЦОГЦ СУРГАЛТЫГ ТОГТМОЛ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА

Хөдөлмөрийн тухай хууль нь Иргэний хуулийн дараа эрэмбэлэгдэхээр томоохон хууль бөгөөд нийгмийн суурь харилцаа болох хөдөлмөрийн харилцааг зохицуулдаг учраас хөдөлмөрийн харилцаанд орж буй бүх тал зайлшгүй анхаарал хандуулах шаардлагатай юм.

Хөдөлмөрийн хууль /шинэчилсэн найруулга/ энэ оны эхнээс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ажил олгогч

шинээр орсон зарчмын болон бусад өөрчлөлтүүдийг дотоод хөдөлмөр зохион байгуулалт, хэм хэмжээгээрээ зохицуулах, санхүүгийн тооцооллоо зөв хийх цогц сургалтыг МҮХАҮТ-ын дэргэдэх Бизнес Академи, өмгөөллийн “Юзисан партнерс” ХХН хамтран 2 дугаар сарын 9-ний өдөр зохион байгуулав.



**МҮХАҮТ 25–500 ХҮНИЙ БАГТААМЖТАЙ ТАНХИМУУДДАА ЗАХИАЛГА АВЧ ЭХЭЛЛЭЭ**

Гишүүнчлэлийн ангиллаас хамаарч хөнгөлөлт эдэлнэ:

Sponsor /25%/  
Diamond /15%/  
Platinum /10%/  
Gold /5%/  
Standard /3%/  
/

Бид та бүхэнд тав тухтай, таатай орчинг санал болгож байна. COVID 19 цар тахлаас сэргийлж, ариутгал халдвартайжүүлэлтийг тогтмол хийж, хүн хоорондын зайл баримтлан үйлчилж байна. 25, 80–100, 400–500 хүний багтаамжтай танхимуудад хурал, сургалт, семинар, бизнес уулзалт, үзэсгэлэн, зөвлөгөөн өдөрлөг, арга хэмжээ, хүлээн авалт зохион байгуулах боломжтой.



**ИХ ТАНХИМ | 500мкв**

400–500 хүн хүлээн авах чадалтай

**ХУРЛЫН ТАНХИМ | 132мкв**

80–100 хүн хүлээн авах чадалтай

**ХУРЛЫН ТАНХИМ | 54мкв**

25 хүн хүлээн авах чадалтай

## МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

### САЛБАР ТАНХИМЫН МЭДЭЭЛЭЛ:

#### БҮС НУТГИЙН ХӨГЖИЛД ЗАЛУУСЫН ОРОЛЦОOG НЭМЭГДҮҮЛЭХЭД ХАМТАРЧ АЖИЛЛАНА

MYXAYT, Увс аймгийн ИТХ болон “ЦойлогосоЖ” төслийн хамтын ажиллагааны цахим уулзалт боллоо. Уулзалтад Увс аймгийн ИТХ-ын дарга Ц.Батболд, MYXAYT-ын Ерөнхий нарийн бичгийн дарга С.Баясгалан, Төсөл хөтөлбөрийн газар, MYXAYT-ын Увс аймаг дахь Кластер багийн зөвлөх С.Сэржим, MYXAYT-ын дэргэдэх залуус руу чиглэсэн “ЦойлогосоЖ” төслийн ахлагч Б.Батзориг болон бусад төлөөллүүд оролцов.

Уулзалтын дүнд залуусын харилцаа холбоо, хамтын ажиллагааг дэмжиж чадавхжуулах замаар бизнесийн орчныг

сайжруулах, цаашлаад олон талын хамтын ажиллагааг хангах, тогтвортой сүлжээг хөгжүүлэх, талуудын харилцан ашигтай түншлэлийг бэхжүүлэх чиглэлээр жишиг аймаг болж залуусын оролцоог нэмэгдүүлж, хамтран ажиллахаар тогтов. Ингэснээр хөдөө орон нутаг, хот, олон улс дахь Монгол залуусын харилцаа холбоог өргөжүүлж, бие биенээсээ суралцаж, хамтран ажиллах боломж бүрдэхийн зэрэгцээ олон улсын байгууллагуудтай хамтран бусад орны залуустай олон талаар хэлхээ холбоо тогтоон ажиллах суурь нөхцөл бүрдэх юм.



### ГИШҮҮН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ:

#### ХААН БАНК ШИНЭ АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГОО ТАНИЛЦУУЛЛАА



Амьдралын их аялалд тань санхүүгийн хөтөч болж, эрхэм таны итгэлт анд байж ирсэн ХААН Банк хөгжлийнхөө нэгэн шинэ хуудсыг нээж, брэндийн шинэчлэл хийж буйгаа олон нийт, харилцагчдадаа танилцууллаа.

ХААН Банкны алсын хараа: “Харилцагчидтайгаа хамт эгнэгт өсөж хөгждөг итгэл төгөлдөр банк байна”

#### Эрхэм зорилго:

“Бид харилцагчдынхаа санхүүгийн аяллын алхам бүрд хамгийн шилдэг, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэнэ”

**Уриа уг:** “Хамтын өсөлт төгөлдөр”

#### Үнэт зүйлс:

- Хөгжил цэцэглэлтийн түүчээлэгч
- Тогтвортой хөгжилд манлайлагч
- Шилдэг цахим бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэгч
- Итгэлт зөвлөгч

ХААН Банкны брэндийн шинэчлэлийн хүрээнд өөр нэг өөрчлөгдсөн зүйл бол банкны лого, бичиглэл илүү өнгөлөг, энгийн, орчин үеийн хэв маягтай болсон. Энэ нь харилцагч, түншүүддээ илүү ойртож, тэдний амьдрал, зорилготой хөл нийлүүлэн алхам хамтран дэмжигч, үнэнч туслах байх гол утга санаатай уялдаж байгаа аж.

### АРГА ХЭМЖЭЭ:

#### ◆ 3 дугаар сарын 3

Ажлын байрны ёс зүй сургалт

#### ◆ 3 дугаар сарын 10

MYXAYT, Иран Улсын Худалдааны Танхим /ICCIMA/ хамтран зохион байгуулж буй цахим B2B уулзалт

#### ◆ 3 дугаар сарын 10

Хөдөлмөрийн тухай хуулийн цогц сургалт

#### ◆ 3 дугаар сарын 15

Harvard ManageMentor хөтөлбөрийн бүртгэл дуусна

#### ◆ 3 дугаар сарын 24

Брэнд нэр, логонд хэрхэн эрхийн хамгаалалт хийх вэ?  
/цахим сургалт/

